

О.Мөнхбат

*МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн багш,
Социологийн ухааны доктор (Ph.D)*

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧЛЭГ: НИЙТЛЭГ ШААРДЛАГА, ЗАГВАРУУД

Abstract: *In the paper “Academic writing: general requirement, styles”, the author analyses current situation of Academic writing at NUM in general in School of Social sciences in particular and promotes idea of policy for standardizing of writing. The author introduces to readers a popular academic writing styles as APA- American Psychological Association, MLA- Modern Linguistic Association and Chicago Style of Academic writing. He analyses experience of universities in developed countries and suggests to approve several writing styles and to adhere to concrete style within one article to standardize writing at the school of social sciences, NUM.*

Key words: *academic writing, APA- American Psychological Association, MLA- Modern Linguistic Association, Chicago Style of Academic writing.*

Ерөнхий мэдээлэл:

МУИС-ийн харьяа нийгэм-хүмүүнлэгийн сургуулиудын хэмжээнд дунджаар хорь гаруй сэтгүүл түүний дотор зөвхөн НШУС-ийн хэмжээнд 12 мэргэжлийн сэтгүүл монгол, англи хэлээр гарч, багш, судлаачдын бүтээн туурвисан олон зуун нэгэн сэдэвт зохиол, сурах бичиг болон гарын авлагууд МУИС, МУИС-ийн харьяа, сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэгдэн дэмжигдэж, тус сургуулийн лого, нэрийн дор хэвлэгдэж байна. Түүнчлэн МУИС-ийг жил бүр төгсөж байгаа докторант, магистрант оюутнууд тус бүрдээ диссертаци диплом зэрэг эрдэм шинжилгээний ажил бичиж хамгаалж байгаа юм.

Дээр дурдсан сэтгүүл, ном бүтээлийн зохиогч тус бүрдээ ишлэл, жишээ татах, ашигласан ном эх сурвалжаа заах зэрэгтээ бичлэгийн өөр өөр хэв загвар баримталж байна. Зөвхөн сэтгүүлийн хувьд гэхэд 20 хэвлэлийн хуудастай нэг дугаарт хэвлэгдэж байгаа бүтээлүүдэд дунджаар 5-6 төрлийн өөр өөр эрдэм шинжилгээний бичлэгийн хэв загвар ашигласан байна. Тэр бүү хэл нэг ЭШ-нийн өгүүллийн хүрээнд хэд хэдэн хэв загвар ашиглах явдал ч нийтлэг болжээ.

Түүнчлэн зарим судлаачид эх сурвалжийг заан тодотголгүйгээр бусдын бүтээлийг хуулах, эсвэл ашигласан нь үнэн эсэх нь үл мэдэгдэх олон арван бүтээлийн нэрийг бүтээлийн төгсгөлд ишлэл зүүлтгүй жагсаан бичих зэргээр хандах нь олонтой тохиолдож байна.

МУИС-д хэвлэгдэж буй эрдэм шинжилгээний бүтээлд баримталбал зохих бичлэгийн хэв загварын нэгдсэн стандарттай холбоотой зарим дүрэм журам байдаг байна. Тухайлбал, “МУИС-ийн Эрдэм Шинжилгээний Бичиг хэвлэхэд баримтлах нийтлэг журам” нь сэтгүүлд хэвлэгдэх ЭШ-ний бүтээлд тавигдах шаардлага, түүний дотор зохиогчоос ишлэл, ашигласан ном зохиолын зүүлт, жагсаалт зэргийг хэрхэн хийхийг журамлан заажээ. Гэхдээ дээрх журам нь өнөөгийн эрдэм шинжилгээний бүтээлд тавигдах шаардлагыг бүрэн тусгаж чадаагүйн улмаас тун хязгаарлагдмал шинжтэйн сацуу түүнийг даган мөрдөх явдал ч тун доогуур түвшинд байна. Дээрх журамд интернет электроник болон гадаад хэлээр хэвлэгдсэн эх сурвалжийг ашиглах, ишлэл хийх, хуулбарлахаас урьдчилан сэргийлэх, ЭШ-ний бүтээлийг хэрхэн бүтэцжүүлэх зэрэг академик бичлэгийн амин чухал шаардлагууд орхигдсоноос гадна эл журмыг даган мөрдөх, таниулан түгээх арга хэлбэрийг огт дурдаагүй байна. Эдгээр нөхцөл байдлаас үүдэн дараах сөрөг үр дагаврууд гарч байгаа юм. Үүнд:

1. Эх сурвалж, жишээ татсан ишлэл зүүлтийг хийх нэгэн стандарт загваргүй байгаа нь тухайн бүтээлийг уншигчид цааш гүнзгийрүүлэн ашиглах, баримтжуулах, номын сангаас хайлт хийх асуудал хүндрэлтэй юм уу эсвэл огт боломжгүй болох,

- МУИС-ийн эрдэмтэн багш нарын бүтээлийг олон улсын мэргэжлийн сэтгүүлүүдэд хэвлүүлэхэд сөрөг нөлөө үзүүлэхийн сацуу бүтээлийн нэр хүнд, ач холбогдлыг эрс бууруулж байна,
- ЭШ-ны бүтээлийн нэгдсэн стандарт байхгүй байгаа нь магистр, докторантур зэрэг ахисан түвшний оюутнуудад ЭШ-ний ажлын арга зүйг эзэмшүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Иймээс тус сургуулийн эрдэмтэн багш нарын бүтээлийн чанарыг дээшлүүлэх, улмаар дэлхийн түвшний академик орон зайд гарах бодит нөхцлийг бүрдүүлэхэд МУИС-ийн хэмжээнд ЭШ-ний бичлэгийн талаар нэгдсэн бодлого стандарт боловсруулж мөрдөх нь зайлшгүй хэрэгцээ шаардлагаар нөхцөлдсөн, тулгамдсан асуудал болж байна.

Түгээмэл хэрэглэгддэг ЭШ-ний бичлэгийн хэв загвар:

ЭШ-ний бичлэгийн хэв загвар гэж аливаа академик бүтээлийг бичих явцад зохиогчоос ишлэл жишээ татах, ашигласан ном, электрон хэвлэл, интернет зэрэг эх сурвалжын зүүлт, жагсаалт хийх, оюуны өмчийн хулгай, хуулбарлахаас зайлсхийх, бүтээлийн бүтцийг томъёолох зэрэгт баримталбал зохих стандарт, хэм хэмжээний цогц тогтолцоог хэлнэ. (Brusaw.T, 2002) Хойд Америк, Европ, Азийн их сургууль, нийгэм хүмүүнлэгийн эрдэм шинжилгээний нэр хүнд бүхий сэтгүүлүүдийн даган мөрддөг ЭШ-ний түгээмэл хэв загваруудыг дараах байдлаар томъёолж болох юм. Үүнд:

- АПА хэв загвар буюу Америкийн Сэтгэл зүйн Холбооны загвар (APA- American Psychological Association);
- МЛА хэв загвар буюу Орчин цагийн Хэл шинжлэлийн Холбооны загвар (MLA- Modern Linguistic Association)
- Чикаго хэв загвар буюу ЭШ-ний бичлэгийн Чикаго загвар (Chicago Style of Academic writing).

Энэхүү загварууд нь компьютер дээр **Windows** орчны програм дээр ашиглахад тун тохиромжтой бөгөөд анхнаасаа суусан байдаг ажээ. Жишээлэхэд: **Word** програм -ийн **Reference** цонхыг нээж **Style**-аас хэрэгтэй бичлэгийн загвараа (тэнд дээр дурдсан болон өөр бусад загвар суусан байдаг) сонгон эх сурвалжаа оруулахад програм автоматаар хэлбэржүүлж, Reference буюу Ашигласан номын жагсаалтыг үүсгэн ямар ч зүйл бичсэн дахин дахин ашиглах боломжийг нээдэг.

Эдгээр хэв загварын хувьд ЭШ-ний бүтээлийн бүтэц, бүрэлдхүүн хэсэг агуулга, бичлэгийн хувьд нэлээд нийтлэг шаардлагыг тавьдаг. Жишээлэхэд зөвхөн ЭШ-ний сэдэв сонголтын хувьд гэхэд л 1) Тулгамдсан, хэрэгцээ шаардлагатай социаль асуудал болохыг үндэсний болоод олон улсын хэмжээнд шинжлэн нотолсон байх, 2) Цаашид ирээдүйтэй, засгийн газар, олон улсын байгууллага, сангуудаас санхүүжих боломжтой байх, 3) Бодит үр дүнд чиглэсэн, тухайн зорилтот бүлгийн хэрэгцээг хангасан шийдлийн хувилбар санал болгохуйц байх зэрэг нийтлэг шалгуур үзүүлэлтийг санал болгодог. (Carter.C, 2003)

Түүнчлэн ном зохиолоос ишлэл авах, оюуны өмчийн хулгайгаас сэргийлэх тал дээр ч үндсэндээ ижилхэн шаардлага тавьдаг байна. Тухайлахад, ном бүтээлээс ишлэл татаж, мэдээлэл ашиглахдаа:

- ▶ Шууд ишлэл (quotation)

Шууд ишлэл гэдэг нь ашиглаж байгаа зохиолоос тодорхой бичвэрийг үг үсэг өөрчлөхгүйгээр хаалт хашилт хэрэглэн авч хэрэглэхийг хэлнэ

Ашиглаж буй номонд:

Нийгмийн ажлын онолын сэтгэлгээ социологийн шинжлэх ухааны онол аргагүйн хүчтэй нөлөөн дор оршино.

Иш татахдаа:

Судлаач О.Мөнхбат (2008) үзэхдээ “Нийгмийн ажлын онолын сэтгэлгээ социологийн шинжлэх ухааны онол аргагүйн хүчтэй нөлөөн дор оршино” гэжээ.

- ▶ Тоймлох (summarizing)

Тоймлох гэдэг нь судлаач ашиглаж буй номны бичвэртэй сайтар танилцаж, түүний зорилго, ашигласан онол арга зүй, хүрсэн үр дүн зэрэг мэдээллийг эх сурвалжид заасан зарим нэр томъёог ашиглах замаар хэрэглэхийг хэлнэ.

Ашиглаж буй номонд:

Нийгмийн ажлын онолын сэтгэлгээ социологийн шинжлэх ухааны онол аргазүйн хүчтэй нөлөөн дор оршино.

Тоймлохдоо:

Судлаач О.Мөнхбат (2008) социологи хийгээд нийгмийн ажлын уялдаа холбоог тэмдэглэж, социологиос энэхүү туслахуйн мэргэжлийн онолын сэтгэлгээнд үзүүлсэн нөлөөг жишээ татжээ.

▶ Утгачлан найруулах (paraphrasing)

Утгачлан найруулах гэдэг нь судлаач ашиглаж буй эх зохиолд өгсөн мэдээллийн утга учрыг өөрийн ойлгосон байдлаар тайлбарлаж бүтээлдээ ашиглахыг хэлэх бөгөөд эхэд дурдсан нэр томъёоноос тун цөөхнийг авч хэрэглэнэ.

Ашиглаж буй номонд:

Нийгмийн ажлын онолын сэтгэлгээ социологийн шинжлэх ухааны онол аргазүйн хүчтэй нөлөөн дор оршино.

Утгачлан найруулахдаа:

Хүний зан үйлийн тухай судалдаг шинжлэх ухаан хийгээд туслахуйн мэргэжлийн хооронд нягт харилцаа холбоо байдгийг судлаачид тэмдэглэх нь байдаг бөгөөд судлаач О.Мөнхбат социологиос нийгмийн ажилд үзүүлсэн нөлөөллийг онцлон тэмдэглээд тодорхой жишээн дээр тайлбарлахыг хичээсэн байна.

Харин эдгээр нь ишлэл зүүлт хийх, жишээ баримт татах тал дээр харьцангуй өөр загварыг санал болгодог. Тэгэхдээ нэг сэдэвт бүтээл, ном, ЭШ-ний сэтгүүлд хэвлэгдсэн үгүүлэл, албан ёсны баримт бичиг, судалгааны тайлан, цахим хуудас, емейл, фасебүүк зэрэг электрон эх сурвалжаас хэрхэн ишлэл хийхийг маш тодорхой зааснаараа нийтлэг билээ.

Жишээ нь, Социологи, Нийгмийн ажил, Философи, Улстөр судлал, Сэтгэл судлал, Антропологи зэрэг нийгмийн ухаанд хамгийн түгээмэл хэрэглэгддэг АПА загвар нь доорхи байдлаар заасан байдаг.

Ном зохиол, сурах бичиг, гарын авлага:

О.Мөнхбат (2008) *Социологийн онол*. Улаанбаатар: УВ принт Хэвлэлийн газар.

Сэтгүүл:

О. Мөнхбат (2008) Социологи болон Нийгмийн ажлын уялдаа холбоо. *Социологи сэтгүүл*. Дугаар 3. 25-29 дүгээр хуудас

Сонин:

О.Мөнхбат (2008-08-19) ХАА-г боловсронгуй болгох замаар авлигатай тэмцэх нь. *Өдрийн Мэдээ Сонин*

Онлайн буюу цахим хуудас гм:

Munkhbat.O (Spring 2008) The mining sector and Unplanned Settlements in Mongolia. *ScholarForum*. Volume 11. retrieved 22Apr, 2011. www.soros.org/initiatives/scholarship

Гадаадын их дээд сургуулиудын туршлага:

Хөгжингүй орнуудын их дээд сургуулиуд эрдэм шинжилгээний бичлэгийн талаар дараах бодлогыг баримталдаг байна. Үүнд:

- А. Их сургууль эсвэл салбар сургуулийн хүрээнд тогтсон нэг загварыг баталж, эрдэм шинжилгээний бүх төрлийн бүтээлд тухайн л загварыг ягштал баримталж, даган мөрддөг.

Энэ тохиолдолд ЭШ-ний тодорхой хэв загвар бүрэлдэн тогтсон сургуулиуд, эрдэмтэд өөрсдийн дадсан загвараас татгалзах, шинэ загварт суралцах зэрэг хүндрэл учирдаг бөгөөд тухайн загварыг түгээн тархаахын тулд нийтийг хамарсан сургалт хийх, ном гарын авлага шинээр зохион хэвлэх зэргээр санхүүгийн ихээхэн зардал шаарддаг.

- В. Тухайн сургууль, салбар сургуулиуд Эрдэм шинжилгээний тодорхой хэдэн загварыг сонгож, нэг ЭШ-ний бүтээлийн хүрээнд нэг л загварыг баримтлахыг шаардана.

Энэ бодлого нь сонголт хийх боломжийг олгохын сацуу нэгэнт тогтсон дадал барилыг өөрчлөхийг шаардахгүйгээр бий болж уламжлагдсан загваруудыг нэгэн системд оруулан, албан ёсоор хүлээн зөвшөөрч, эргэлтэнд оруулах давуу талтай бөгөөд цаг хугацаа, хүн хүч, санхүүгийн өндөр зардал шаардлагагүй.

С. Дэлхийн нэр хүндтэй их сургуулиудын баримталдаг бүхий л бичлэгийн загварыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд нэг ЭШ-ний ажлын хүрээнд нэг л загварыг баримтлахыг шаардана.\

Энэ бодлого нь эрдэмтэн судлаачдын сонголт хийх эрхийг хамгаалдаг боловч ЭШ-ний загвар хэт олширч, ЭШ-ний бичлэгийн хичээл заах, заавар зөвлөгөө өгөхөд хүндрэл гардаг эрсдэлтэй ажээ.

МУИС-ийн НШУС-ийн тухайд:

НШУС-ийн тэнхмүүд нь Монгол улсдаа анхдагчид бөгөөд ЭШ-ний арвайн туршлага хуримтлуулсан зэрэг цолтой эрдэмтэн судлаачид олонтой сургууль гэдгээрээ онцлог. Энэ утгаараа ЭШ-ний бичлэгийн тодорхой хэв загвар нутагшсан, даган мөрддөгдөг юм.

НШУС-ийн хувьд салбар сургуулийн хэмжээнд эрдэм шинжилгээний тодорхой хэдэн загварыг сонгож, нэг ЭШ-ний бүтээлийн хүрээнд нэг л загварыг баримтлахыг шаарддаг В загвар тохиромжтой санагдана. Үүнийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зохистой мэт. Үүнд:

- Тэнхмүүдийн түгээмэл хэрэглэдэг ЭШ-ний бичлэгийн загварын жагсаалт гарган тэдний албан ёсны нэр, үсгэн товчлолыг гаргах,
- Сургуулийн салбар эрдмийн зөвлөлөөр НШУС-ийн хэмжээнд баримтлах ЭШ-ний хэв загварын жагсаалтыг баталж гаргах,
- НШУС-ийн лого, нэр тавьсан бүхий ЭШ-ний бүтээлүүдэд дээрх загваруудыг мөрдөх, ингэхдээ нэг ажлын хүрээнд зөвхөн нэг л загварыг баримтлах
- Магистр, Докторантурт ордог ЭШ-ний бичлэг хичээлийн нийтлэг хөтөлбөрийг боловсруулан заадаг болох,
- Оюутны үйлчилгээний хүрээнд ЭШ-ний бичлэгийн зөвлөгөө өгдөг тогтолцоог НШУС-ийн хэмжээнд үүсгэх

Ашигласан ном зохиол

1. Brusaw.T, O. (2002). *Writing: From A to Z*. USA: Mcraw-Hill Higher Education.
2. Carter.C, A. (2003). *How to write a Grant proposal*. New Jersey: John Wiley and Sons, Inc.
3. Социологи, Нийгмийн ажлын тэнхим (2010-2012). О.Мөнхбат ЭШ-ний бичлэгийн ур чадвар хичээлийн материал.